

СҮЛД ЧУУЛГЫН 2021 ОНЫ ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021.07.05

Улаанбаатар хот

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр

Тус чуулгаас 2021 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, биелэлт, үр дүнг тооцох 25 баримт бичгийн жагсаалтын дагуу зүйл, заалт тус бүрээр алба хаагч нарт хариуцуулж батлуулан эхний хагас жилээр биелэлтийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 28- Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу 27 зүйл заалтын биелэлт үр дүнг тооцон тогтоосон хугацаанд хэрэгжилтийг нэгтгэх, зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх холбогдох алба, нэгжид хүргүүлж ажилласан.

Эхний хагас жилд цагдаа, дотоодын цэргийн анги байгууллага болон бусад газраас 632 ирж, 471 албан бичгийг хүргүүлж, захиргааны 12 боловсон хүчний 38 тушаал гаргасан байна.

Чуулгын даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн тушаалаар Сүлд чуулгын дотоод журмыг шинэчлэн боловсруулж алба хаагчдаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Чуулгын даргын санаачилгаар ажлын өдрүүдэд чуулгын ерөнхий эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй офицер алба хаагч нар рапортын дэвтэрт 1-3 санал бичиж байхыг үүрэг болгосон бөгөөд 2021 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 117 алба хаагчаас 120 санал гарч, түүний дагуу холбогдох албан тушаалтанд чуулгын даргаас хугацаатай үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг хангаж ажилласан нь алба хаагчдын оролцоог хангаж, идэвх санаачилгыг нэмэгдүүлэхээс гадна чуулгын хэмжээнд тулгамдаж буй асуудлыг олж харах, шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлж байгууллагын соёлыг дээшлүүлэхэд нөлөөлсөн юм.

“Өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 02 дугаар сарын А/50 дугаар тушаалын дагуу 2021 оны 02 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газар хэлтсүүдэд нэмэгдлээр 45 алба хаагч, 2021 оны 04 дүгээр сарын 09-ны А/103 дугаар тушаалаар Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын хоёрдугаар хэлтэст 04 дүгээр сарын 10-аас 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэл тус чуулгаас 42 алба хаагч явган эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажилласан бөгөөд өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжин ажиллах хугацаанд чуулгын алба хаагчдаас албаны бэлэн байдал, ажлын хариуцлага, сахилга ёс зүйтэй холбоотой зөрчил дутагдал заагдаагүй болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Тээврийн цагдаагийн албанд нэмэгдлээр нийт 35 алба хаагч 2021 оны 06 дугаар сарын 08, 09-ны өдрүүдэд Замын хөдлөгөөний аюулгүй байдлыг хангах болон Сонгуулийн хэсгийн хороо, сонгуулийн байрны орчим замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажилласан. Нэмэгдлээр үүрэг гүйцэтгэх хугацаанд тус чуулгын алба хаагчдаас албаны бэлэн байдал, ажлын хариуцлага, сахилга ёс зүйтэй холбоотой зөрчил дутагдал заагдаагүй болно.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ны “Объектын хамгаалалтын хуваарь батлах тухай” А/334 дүгээр тушаалаар тус чуулгын 6 алба хаагч Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Би-Жи” зочид буудал тусгаарлан ажиглах байрны хамгаалалтад зөрчил дутагдалгүй үүрэг гүйцэтгэсэн.

Дотоод аюулгүй байдлыг хангах ЦБҮАЖ /код 113/-ийг хэрэгжүүлэх чуулгын аюулгүй байдлыг хангах, жижүүрийн алба хаагчдын сонор, сэрэмжийг дээшлүүлэх, арга зүйн зөвлөгөө өгөх, алдаа дутагдлыг засуулах зорилгоор “Байгууллагын дотоод аюулгүй байдал чуулгын жижүүрийн алба хаагчдын үйл ажиллагааг шалгах ажлын удирдамж”-ийг чуулгын даргаар батлуулан шалгалтыг явуулж дүнг чуулгын даргад танилцуулж ажилласан.

Нийт 201 ширхэг цаасан суурьтай 70 жил хадгалах Боловсон хүчний болон Захиргааны тушаалуудыг цахим хэлбэрт оруулж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын сейфэнд дугаарлан байршуулж /6 терабайт/ цахим баримтыг Цагдаагийн байгууллагын анхан шатны архивын дүрмийн 2.1.7-д заасны дагуу CD.DVD-нд буулгаж хадгалсан.

Сургалт, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр

Тус чуулга нь Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/02 дугаар тушаалаар баталсан “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөө, 62 сэдвээр 140 цагийн хичээл бүхий хөтөлбөрийг чуулгын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллав.

2021 оны эхний хагас жилд 46 сэдвээр 70 цагийн сургалтыг давхардсан тоогоор 2958 алба хаагчийг хамруулан цахим хэлбэрээр хийж, мэдвэл зохих хууль тогтоомжийн 10, алба хаагчийг хөгжүүлэх 7, дадлагажуулах 2 сургалтыг зохион байгууллаа.

Тухайлбал, Удирдах ажилтны сургалт, зөвлөгөөний үеэр явагдсан “Мэдээллийг багцлах, олон нийтэд хүргэх арга зүй”, “Байгууллагын соёлын хөгжил ба загварчлал”, “Байгууллагын хөгжилд инноваци хийх мэддэгийн менежмент”, “Төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин”, Эрүүл мэндийн сургалт “Биеийн жингийн индекс, таргалах шалтгаан ба онцлог”, “Спортын гэмтлээс урьдчилан сэргийлэх нь видео хичээл”, “БНСУ-ын засгийн газраас “Ковид-19” цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ болон үндэсний цагдаагийн газрын үүрэг, “Миний японд ирсэн түүх”, “Коронавируст халдвар ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, дархлаажуулах вакциныг хүлээн авах, түгээх, хадгалах, дархлаажуулах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамгаалалт зохион байгуулах түр заавар”, “Цагдаа, дотоодын цэргийн “Түр хүрээ”-ний Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх багаас 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 01 дүгээр сарын 15-ны хооронд 37 анги байгууллагын 4103 алба хаагчаас авсан Сэтгэл санааны байдлын өөрчлөлтийг судалж, тулгамдсан асуудлыг тодорхойлох судалгааны тайлан”, “Хууль сахиулах үйл ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэх тухай албан даалгавар”, “Зөрчлийн тухай хууль”, “Хувь хүний нууц, холбогдох мэдээллийг хамгаалах харилцааг зохицуулж буй эрх зүйн орчин болон практикийн судалгаа”, “ЦЕГ-ын дэд даргаас өгсөн Ковид-19 цар тахлаас сэргийлэх тухай үүрэг ажлын чиглэл”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Авлигаас урьдчилан сэргийлэх нь- Авилгатай тэмцэх газраас

нийтийн албан тушаалтнуудад зориулсан Ашиг сонирхол зөрчлийн тухай сургалт", "Радио холбооны сүлжж сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам", "Алба хаагчид Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан "Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрнгө, орлогын мэдүүлэг", "Чуулгын дотоод журам", "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн ойлголт, ЦБҮАЖ код-922 " Ялгаравлан гадуурхах, ажлын байрны бэлгийн дарамтаас хамгаалах" журам", "Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам", "ЦБҮАЖ код-209 Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх", "Халварт Өвчний тандалт судалгааны алба, Кластерийн хяналтын багаас өгсөн Коронавируст халдвар бүртгэгдсэн байгууллага аж ахуйн нэгж хэрэгжүүлэх арга зүйн заавар зөвлөмж", "Цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрлөх эрх", "Аюулгүй байдлын хэлтсээс ирүүлсэн зөвлөмж", "Стрессээс сэргийлэх энгийн аргууд", "Алхалтын ач тус", "Унадаг дугуйн ач холбогдол, анхаарах асуудал", "Газар хөдлөлтийн үед өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах энгийн зөвлөмж", "Алба хаагчдад төрийн одон медаль, цол, хууль зүй дотоод хэргийн яам, соёлын яамны шагнал, цагдаагийн байгууллагын шагналын талаарх мэдээлэл өгөх, шаардлага шалгуурын талаар ойлголт", "Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам", "Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед хамгаалалт зохион байгуулах арга, тактик /ЦБҮАЖ код 500, 503/", "МУ-ын ЗГ-ын 152 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит үед коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 238", "Коронавируст халдвар илэрсэн объектыг хамгаалах түр журам", "Гэр /амрах байр/ийн тусгаарлалт, ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам", "Цагдаагийн алба хаагчаас хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах нь", "Алба хаагчдын иргэдтэй харилцах, биеэ авч явах байдлын тухай видео хичээл", "Туулийн тухай, туулийн хэлбэр, бэлгэдэл", "Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаа" зэрэг болно.

Чуулгаас Дотоод Хэргийн Их сургуулийн бакалаврын 2021-2022 оны хичээлийн жилийн эчнээ сургалтад 1 алба хаагч, Их засаг хууль зүйн сургуулийн бакалаврын эчнээ сургалтад 1, магистрантурт 2, Монгол Улсын Их сургуулийн докторын сургалтад 2 алба хаагч хамрагдаж байна.

Уран сайхны удирдагч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Амарболд Дотоод Хэргийн Их сургуульд суралцаж, "Цагдаагийн ажил-Эрх зүй"-н мэргэжил, Бүжгийн хэсгийн ахлагч, цагдаагийн ахлагч А.Эрдэнэбаяр Соёл урлагийн их сургуулийн бакалаврын эчнээ ангид суралцаж бүжгийн багш мэргэжил, бүжигчин, цагдаагийн ахлах ахлагч Э.Ундраа, цагдаагийн ахлагч Э.Жаргалмаа, цагдаагийн дэд ахлагч Б.Гантогтох нар Их засаг их сургуулийн Хууль зүйн сургуулийн бакалаврын эчнээ сургалтад хамрагдан, амжилттай төгсөж эрх зүйч мэргэжил тус тус эзэмшсэн.

Дотоод Хэргийн Их сургуулийн бакалаврын 2021-2022 оны хичээлийн жилийн эчнээ сургалтад Соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг суралцахаар шалгаруулалтад тэнцсэн.

Чуулгын офицер бүрэлдэхүүнээс 5, ахлагч бүрэлдэхүүнээс 5 эрх зүйч мэргэжилтэй алба хаагч байгаагийн 6 алба хаагч соёл урлагийн болон хууль эрх зүйн хос мэргэжилтэй байгаа нь нэг талаас байгууллагын удирдлагын зүгээс мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх сургалт хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан алба хаагчдыг дэмжиж, суралцах нөхцөл бололцоогоор ханган

ажиллаж ирсний үр дүн, нөгөө талаар бие бүрэлдэхүүн цагдаагийн албаны онцлогийг ухамсарлан ойлгож, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх гэсэн эрмэлзэл, хандлагатай холбоотой юм.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны Б/137 дугаар тушаалаар Дотоод Хэргийн Их сургуулийн Ахлагчийн сургуультай хамтран зохион байгуулж буй “Цагдаа” мэргэжил олгох цахим сургалтад хөгжимчин Мөнхтөрийн Цэрэнчунт болон сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан 6 иргэн хамрагдаж төгссөн.

Чуулгын дарга болон Захиргааны удирдлагын тасгийн дарга нар Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 1.0 багц цагийн сургалтад хамрагдаж, УАС/2021-052, УАС/2021-053 дугаартай гэрчилгээ, Монгол Улсын ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЦДЦСНТ-өөс Монгол бичгийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан Үндэсний бичгийн сургагч багш бэлтгэх 2.5 багц цагийн сургалтад Музейн эрхлэгч, эрдэм, шинжилгээ, сургалт хариуцсан ахлах ажилтан, цагдаагийн ахмад С.Дуламсүрэн хамрагдаж, СБМ/2021-0047 дугаартай гэрчилгээ, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран зохион байгуулсан “Сургалт заах арга зүй” сэдэвт сургагч багшийн сургалтад СГАСХАМ, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг хамрагдаж, 2021/СБ-064 дугаартай гэрчилгээ, цагдаагийн алба хаагчдад зориулсан “Ёс суртахуун-Төлөвшил, хандлага” сэдэвт ёс зүйн сургалтад бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар /2021/ТС-А-098/, бүжигчин, цагдаагийн ахлагч М.Энхзолбоо /2021/ТС-А-099/, хөгжимчин, цагдаагийн дэд ахлагч Б.Батзориг /2021/ТСА-100/ нар хамрагдаж тус бүр гэрчилгээ гардав.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын “Сахилга, ёс зүй, хариуцлага”-ын цахим зөвлөгөөнд 3 алба хаагч, “Цагдаа, дотоодын цэргийн ахлагч бүрэлдэхүүний 2021 оны сургалт, зөвлөгөөн”-д 38 ахлагч, Цагдаагийн ерөнхий газар, Хүний эрхийн үндэсний комисстой хамтран зохион байгуулсан хүний эрхийн мэдлэг, боловсрол олгох цахим сургалтад 7 алба хаагч, Засгийн газрын хэрэг эрхлэх газраас Засгийн газрын 2020 оны 206, 216, 217, 218 дугаар тогтоолоор баталсан журмуудын талаар бэлтгэсэн 4 төрлийн модуль сургалтад тус чуулгын ахлах болон түүнээс дээш албан тушаалын 3 алба хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.

Чуулгын даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар “Сүлд чуулгын дотоод журам”-ыг шинэчлэн баталсантай холбогдуулан 35 асуулт бүхий тест, Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед хамгаалалт зохион байгуулах арга, тактик /ЦБҮАЖ код 500, 503/, Гэр /амрах байр/ийн тусгаарлалт, ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам, “Коронавируст халдвар илэрсэн объектыг хамгаалах түр журам, “Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын цахим шалгалтыг Гүүгл форм /Google form/-оор авч, А-38, В-31, С-27, D-17, F-41 үнэлгээтэй дүгнэгдсэн.

Тус чуулгын Музейн эрхлэгч, эрдэм, шинжилгээ, сургалт хариуцсан ахлах ажилтан, цагдаагийн ахмад С.Дуламсүрэн цагдаагийн сэдэвт дууны видео хичээл, бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар “Оффис биелгээ” цахим сургалтыг бэлтгэн чуулгын цахим хуудсанд байршуулж ажилласан.

Мэдээлэл сурталчилгаа: Цахим сүлжээнд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах, алба хаагчдын ажил алба, амьдралдаа

хандах эерэг хандлага, сэтгэлгээг төлөвшүүлэх чиглэлээр видео контентүүдийг бэлтгэн байршуулж, олон нийтийн хандалтыг авч ажилласан. Тухайлбал “Бид эх орондоо хайртай”/220.000 үзэгч/, “Цахимаар золгоё” /105.000 үзэгч/, “Ковидгүй зуны төлөө” /406.000 үзэгч/ зэрэг олон нийтийг эерэг үйл ажиллагаанд уриалан дуудсан хөдөлгөөнүүдэд чуулгын бие бүрэлдэхүүн нэгдсэн.

Цахим хуудсаар бусад цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 17 мэдээ, мэдээлэл сэрэмжлүүлгийн холбоос, 66 видеог чуулгын цахим хуудаснаа хуваалцаж, 166 видео мэдээ, 283 зурагт нийтлэлийг байршуулж ажилласан.

Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс ковид-19 цар тахлын үеийн явган эргүүлд ажилласан чуулгын болон Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн алба хаагч нарын дархлааг нь дэмжих зорилгоор үүрэг гүйцэтгэх үед нь халуун аарц, чацаргана, витамин, амны хаалт, нэг удаагийн бээлий, гар ариутгагч зэргийг тараасан нь тэдний сэтгэл зүйд эерэгээр нөлөөлж, ажлын стрессийг тайлахад нөлөөлсөн үр дүнтэй ажил болсон.

Соён гэгээрүүлэх ажил: 2021 оны эхний хагас жилд 25 удаагийн соён гэгээрүүлэх ажилд давхардсан тоогоор 1708 алба хаагч, ажилтныг хамруулан зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 олын А/64 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын дунд 2021 онд зохион байгуулах соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний биелэлтийг 87%, 4.4 үнэлгээтэйгээр дүгнэн СГАСХ-т хүргүүлэв.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2021 онд хэрэгжүүлэх “Үргэлж тантай хамтдаа” цахим соён гэгээрүүлэх өдөрлөгийн төлөвлөгөө, хуваарийг ЦЕГ-ын ЗУГ-ын даргаар батлуулан батлагдсан хуваарийн дагуу 2021 оны 03 дугаар сард СХДЦГ-тай хамтран зохион байгуулж байгаа болно.

Монгол Улсын төрийн дууллыг чуулгын уран бүтээлчдээр дуулуулж, дүрсжүүлэн мэргэжлийн студид бичүүлэн CD дээр бичиж олшруулан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад хүргүүлсэн.

Чуулгын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс санаачлан эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, эерэг хандлага, зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор “Эерэг хандлага-Эрүүл бие” 1 сарын хөтөлбөрийг үе шаттайгаар зохион байгуулав. Эхний үе шат нь чуулгын эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөр бөгөөд 7 хоногийн 3 өдөр дасгал хөдөлгөөн хийж, эрүүл зөв хооллолтын дэглэм барьж, өдөр тутмын амьдралдаа эерэг дадлыг хэвшүүлсэн.

Цагдаагийн байгууллагын 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Монгол улсад хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой 2021 онд тохиохтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангах шинэчилсэн төлөвлөгөө”-ний урлаг соёлын ажил хариуцсан дэд ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, хэрэгжилтийг хангав.

Урлаг соёлын ажил, арга хэмжээний хүрээнд хийгдэх 15 ажлаас 100%-ийн биелэлттэй 5, 90%-ийн биелэлттэй 1, 80%-ийн биелэлттэй 2, 70%-ийн биелэлттэй 2, 50%-ийн биелэлттэй 3, 40%-ийн биелэлттэй 2 ажил, арга хэмжээ байгаа бөгөөд нийт хэрэгжилтийн явц 84% хувь буюу 4.2 үнэлгээтэй байна.

Төлөвлөгөөний 3.1. “Цагдаагийн ахмад, дунд, залуу үе” сэдэвт уулзалтыг үе

шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд 2020 онд 23 ахмад ажилтантай хамтран “Цагдаагийн ахмад, дунд, залуу үе” сэдэвт уулзалтыг 109 удаа зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 2207 алба хаагчийг цахимаар болон танхимын хэлбэрээр хамруулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад “Цагдаагийн ахмад, дунд, залуу үе” сэдэвт уулзалт зохион байгуулсан ажлын дүн мэдээг, 47 анги, байгууллагаас хүлээн авч, дүнг нэгтгэн ЦЕГ-ын Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтэст хүргүүлэв.

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, дунд, залуу үе” сэдэвт уулзалтыг 2021 оны эхний улиралд Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгжүүдээс 20, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын хэмжээнд 4, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдээс 40, нийт 64 ажил, арга хэмжээ зохион байгуулагдсан байна.

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын түүхэн хөгжил, цаашдын чиг хандлага” сэдвээр “Ахмад, дунд, залуу үеийн уулзалт, хэлэлцүүлэг”-ээр телевизийн контент бэлтгэх талаар удирдлагаас чиглэл авч, Захиргааны удирдлагын газрын даргын энэ оны 05 дугаар сарын 12-ны өдөр 5/78 дугаартай албан бичгийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизэд хүргүүлэн тус телевизийн 600-ийн студид 2021 оны 06 дугаар сарын 26-ны “Бямба” гарагийн 12.00 цагаас бичлэгийг эхлүүлэхээр төлөвлөсөн байсан боловч ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас тодорхойгүй хугацаагаар хойшилсон байна.

Төлөвлөгөөний 3.2. дахь Хүүхдүүдийн дунд гар зургийн уралдааныг явуулж шалгаруулан, уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг цахимаар сурталчлах ажлын хүрээнд “Бидний баатар цагдаа” сэдэвт хүүхдийн гар зургийн уралдааны удирдамжийг боловсруулан, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, Хүүхдийн урлан бүтээх төвийн захирал нараар батлуулж, уралдааныг 50 хоногийн хугацаанд зохион байгуулж 646 бүтээлийг биетээр болон цахимаар хүлээн авч шалгаруулан цахим орчинд байршуулж сурталчлан, шагнал гардуулах ёслолыг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Сүлд чуулгын байранд зохион байгууллаа.

Тус уралдааныг Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, Урлаг судлалын ухааны доктор, зураач, багш Н.Баатарцог, урлаг судлаач Б.Учрал, зураач М.Чинбат, Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв, ЦЕГ-ын төлөөлөл оролцсон шүүгч нарын бүрэлдэхүүн шүүж, дүнгээ гаргасан.

Уралдааныг шүүхдээ удирдамжид заасны дагуу хүүхдийн уран сэтгэмжээр зурагдсан, ном, сэтгүүл, сурах бичгээс хуулбарлаагүй, цагдаагийн байгууллагын 100 жилийн түүхэн хөгжлийг үзэж судлан, техник хэрэгсэл, үйл ажиллагаа, албаны хувцас гэх мэт онцлогуудыг тусгасан байх гэх зэрэг шалгуурыг үндэслэн шүүсэн.

Уралдаанд 1-3, 4-6, 7-9, 10-12 дугаар ангийн сурагч, хүүхдүүдийг 4 насны ангиллаар шалгаруулж, 1, 2, 3 дугаар байр тус бүр 1, тусгай байр 2, насны ангилал бүрт 5, нийт 20 шагналт байранд бүтээл шалгарсан. Мөн шилдэг 60 бүтээлийг шалгаруулж батламж гардуулан өглөө.

Төлөвлөгөөний 3.3. дахь Яруу найргийн наадмыг зохион байгуулан шалгаруулж, цагдаагийн сэдэвтэй дуу, шүлэг, яруу найргийн бүтээлийг цахим хэлбэрээр сурталчлах ажлын хүрээнд Монголын зохиолчдын эвлэлийн удирдах

зөвлөлд хамтран ажиллах санал, удирдамжийн төслийг 26/16 дугаартай албан бичгээр хүргүүлж, тус зөвлөлөөс саналыг хүлээн авч, хамтран ажиллахад бэлэн байгаа тухай 01/02 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн. Мөн 2021 оны “Болор цом-38” яруу найргийн наадмыг цагдаагийн байгууллагын 100 жилийн ойн нэрэмжит болгон зохион байгуулах саналтай байгаагаа илэрхийлсний дагуу жил бүр уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн 38 дахь удаагийн “Болор цом” яруу найргийн наадмыг Монголын зохиолчдын эвлэлтэй хамтран зохион байгууллаа.

“Болор цом” яруу найргийн наадмын удирдамжийг 10.5 сая төгрөгийн төсөвтэйгээр 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр ЦЕГ-ын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Монголын зохиолчдын эвлэлийн удирдах зөвлөлийн дарга Д.Цэнджав нараар батлуулан, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын даргын 41 дүгээр тушаалаар Санхүү, аж ахуйн алба, Дотоодын цэргийн штаб, Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Хэвлэл мэдээллийн төв, чуулгын нэр бүхий албан тушаалтнуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж, Захиргааны удирдлагын газрын даргаар батлуулсан бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан.

“Болор цом-38” яруу найргийн наадмын эхний шатанд 126 яруу найрагчийн бүтээл, цагдаагийн 43 алба хаагч, ахмад ажилтнуудын шүлэг яруу найраг ирүүлснээс 30 яруу найрагчийг шалгаруулж, дараагийн шатанд оролцуулсан юм.

Яруу найргийн наадамд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас оролцох 6 алба хаагч, ажилтныг сонгон шалгаруулах ажлын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага болон Цагдаагийн байгууллагын ахмадын холбоонд яруу найраг идэвхтэй бичиж буй алба хаагч, ажилтны талаарх мэдээллийг, бичсэн шүлгийн хамт ирүүлэх тухай 05 дугаар сарын 12-ны 25/327 дугаартай албан бичиг хүргүүлж, 49 байгууллагаас хариу ирсний 19 нь оролцох алба хаагч байхгүй, 5 нь шүлэг ирүүлээгүй, 25 нь нийт 43 алба хаагчийн мэдээлэл болон яруу найргийн бүтээлийг ирүүлсэн байна. Мөн 4 Ахмад ажилтны 14 шүлэг ирүүлснийг МЗЭ-тэй хамтран шалгаруулж, Болор цом-38 яруу найргийн наадамд оролцох алба хаагчдыг сонгох ажлыг зохион байгууллаа.

Цагдаагийн байгууллагаас ахмад ажилтан МЗЭ-ийн шагналт яруу найрагч, цагдаагийн бэлтгэл хурандаа Санжхүүгийн Цэвээнлхаазал, МЗЭ-ийн шагналт яруу найрагч, цагдаагийн бэлтгэл хошууч Жамбалын Алтангэрэл, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч, цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч Дандарын Ганболд, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн НХЖХТ-ийн эргүүлийн офицер, цагдаагийн дэслэгч Дашийн Базарсад, Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах хэлтсийн зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Сайнжаргалын Сэр-Од, Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн Эрүүлжүүлэх, саатуулах байрны эмч, цагдаагийн ахмад Бадрахын Эрдэнэбилэг нар оролцож, “Болор цом-38” яруу найргийн наадмын тайзнаа цагдаагийн сэдэвт яруу найргийн бүтээлүүдээсээ сонордуулсан юм.

Цагдаагийн байгууллагаас төлөөлөн оролцсон алба хаагч, ахмад ажилтнуудаас МЗЭ-ийн шагналт яруу найрагч, цагдаагийн бэлтгэл хурандаа Санжхүүгийн Цэвээнлхаазал шилдэг 10-т үлдэж “Төрийн дуулал эгшиглэж байна” шүлгээ уншсан.

Яруу найргийн наадмын хэвлэлийн бага хурлыг 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдөр “Өдрийн сонин”-ны “Асуух эрхийн танхим”-д зохион байгуулж чуулгын дарга, цагдаагийн хурандаа Г.Эрдэнэбаатар, МЗЭ-ийн дарга До.Цэнджав, Яруу

найргийн төвийн тэргүүн Ж.Баяржаргал, Монголын үндэсний олон нийтийн телевизийн ерөнхий найруулагч А.Минжин, МУСГЗ Ш.Гүрбазар нар оролцож 12 хэвлэл мэдээллийн байгууллагаас мэдээ, сурвалжлага бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

“Болор цом-38” яруу найргийн наадам 2021 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Чуулгын концертын их танхимд зохион байгуулагдаж, хөтлөгчөөр МҮОНТВ-ийн нэвтрүүлэгч Б.Гантигмаа, яруу найрагч Н.Минжинсайхан нар ажиллаж, ерөнхий шүүгчээр МЗЭ-ийн Яруу найргийн Үндэсний төвийн дарга, Д.Нацагдоржийн болон МЗЭ-ийн шагналт яруу найрагч Жамсрангийн Баяржаргал, МУСГЗ, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт яруу найрагч Бямбажавын Хүрэлбаатар, Шагдарсүрэнгийн Гүрбазар, МЗЭ-ийн шагналт зохиолч, Утга зохиол судлаач, хэлбичгийн ухааны доктор Пүрэвхүүгийн Батхуяг, МЗЭ-ийн гишүүн яруу найрагч, Хэл шинжлэлийн ухааны доктор Дагийранзын Нямдорж нар ажиллалаа.

Тэргүүн байр эзэлж, “Болор цом”-ын эзнээр Монголын зохиолчдын эвлэлийн нэрэмжит шагналт, яруу найрагч Оюунцэцэгийн Цэнд-Аюуш “Хүннү хүн” шүлгээр шалгарч “Янжинлхам бурханы зурмал хөрөг”, “Болор цом”, “Цагаан шонхор” цом, “Д.Нацагдорж цом”, 19 дэх жилдээ ивээн тэтгэж буй “Ур ундрах” компанийн “Монгол дээл”, удирдамжид заасны дагуу өргөмжлөл, 3.000.000 төгрөг, цагдаагийн байгууллагын дурсгалын зүйлээр шагнуулсан.

Дэд байрт Болор цомын эзэн, Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагч Мөнгөнхүүгийн Отгонбаяр “Гоонь эр” шүлгээр шалгарч өргөмжлөл, 1.500.000 төгрөг, цагдаагийн байгууллагын нэрэмжит шагналаар, гутгаар байрт Г.Сэр-Одын нэрэмжит шагналт яруу найрагч Сайнжаргалын Начин “Яруу найргийг яаж бичихийг заагаад өг” шүлгээр шалгарч өргөмжлөл, 1.000.000 төгрөг, дөрөвдүгээр байрт Г.Сэр-Одын нэрэмжит шагналт яруу найрагч Чулуунбаатарын Ууганбаяр “Орчлонгийн ай сав” шүлгээр шалгарч өргөмжлөл, 500.000 төгрөг, тавдугаар байрт Монголын зохиолчдын эвлэлийн нэрэмжит шагналт яруу найрагч, “Алтан өд” шагналын эзэн Дамбын Одгэрэл “Ааруулаа оруулахыг минь хараад” шүлгээр шалгарч өргөмжлөл, 300.000 төгрөг, цагдаагийн байгууллагын дурсгалын зүйлээр тус тус шагнагдлаа.

Түүнчлэн амжилттай оролцсон эхний болон 2 дахь шатнаас хасагдсан 25 яруу найрагчид тус бүр өргөмжлөл, мөнгөн шагнал, цагдаагийн байгууллагын нэрэмжит шагналыг гардуулав.

Яруу найргийн наадмын үеэр Багануур дүүргийн засаг даргын тамгын газар, “Утга зохиол, урлаг” сонин, “Цог” сэтгүүл, “Иргэдийн шударга шүүх” ТББ-аас нэрэмжит шагнал гардуулж, Сэлэнгэ пресс ХХК-ийн Ананд хэвлэлийн газраас 1 яруу найрагчид өргөмжлөл, үнэ бүхий зүйл, 1 сая төгрөгийн үнийн дүнд ном хэвлүүлэх эрхийн бичгээр шагнасан юм.

Бичлэгийг 38 дахь жилдээ хамтран ажиллаж буй Монголын үндэсний олон нийтийн телевиз бүрэн эхээр бичиж, Ардын хувьсгалын 100 жилийн ойн их баяр наадмын дараа тус бүр 60 минутын 2 нэвтрүүлэг бэлтгэн эфирт цацахаар эвлүүлгийн ажил явагдаж байгаа болно.

“Болор цом-38” яруу найргийн наадам зохион байгуулагдсан талаар montsame.mn, news.mn, dailynews.mn, ergelt.mn, polit.mn, police.gov.mn, peoplenews.mn, unuudur.mn, npost.mn, dnn.mn, urlag-soyol.mn сайтуудаар болон Цагдаагийн ерөнхий газар, Монголын зохиолчдын эвлэл, Сүлд чуулгын фэйсбүүк

хуудсаар мэдээлж, сурталчилсан.

Яруу найргийн наадмын үеэр чуулгын дарга Монголын зохиолчдын эвлэлийн “Утга зохиолын төлөө” хүндэт тэмдэгээр, соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямцэцэг МЗЭ-ийн 90 жилийн ойн хүндэт тэмдэгээр тус тус шагнуулсан болно.

Зохион байгуулсан ажлын танилцуулгын ЦЕГ-ын тэргүүн дэд даргад 25/501 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

Төлөвлөгөөний 3.4. дэх “Орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулах” ажлын хүрээнд Засгийн газрын 2021 оны 171 дүгээр тогтоолтой холбогдуулан Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан тул хүндэтгэлийн тоглолтыг цахим хэлбэрээр зохион байгуулахад шаардагдах 44 сая төгрөгийн төсвийг өргөтгөсөн хуралд танилцуулж, удирдлагуудаас дахин нягталж, эцсийн байдлаар танилцуулах чиглэл өгсний дагуу 39 сая төгрөгийн төсвийг танилцуулахаар бэлтгэсэн байна.

Орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүндэтгэлийн тоглолтод тоглогдох “Цагаан шонхор” удиртгал хөгжим, Нар сарны зааг киноны хөгжим, Мөрдөн байцаагчийн үйлс, Миний монгол, Бид мартахагүй, Жаргалтайн дэлгэр Монгол, Их хүндэтгэл, Зүрх сэтгэлийн дуулал, Монгол төрийн цагдаа зэрэг бүтээлүүдийн хөгжмийн бичлэгүүдийг Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын “Аялгуу” хөгжмийн студид хийсэн.

Төлөвлөгөөний 3.5. дахь Цагдаагийн байгууллага, алба хаагчийн баатарлаг үйлс, алдар гавъяа, үйл ажиллагааг харуулсан уран сайхны кино бүтээлгэх. “Юник медиа партнершип” ХХК-ийн “Зөөвөрлөгч” кино төслийг ЦЕГ-ын удирдлагуудад танилцуулж, зохиолыг шинэчлэн найруулж, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.

“Юник медиа партнершип” ХХК-тай байгуулах гэрээний төслийг боловсруулж, ЦЕГ-ын Санхүү, аж ахуйн алба, Аюулгүй байдлын хэлтсээс саналыг авч нэгтгэн, Хуулийн хэлтэст хянуулахаар хүргүүлж, ойн бэлтгэл ажлын өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж, өгсөн чиглэлийн дагуу гэрээний төсөлд өөрчлөлт оруулсан. Зохиол болон гэрээний төслийг өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлсэн.

Төлөвлөгөөний 3.6. дахь “Сүлд” чуулгын уран бүтээлийг 10-аас доошгүй аймаг, сумын иргэд, олон нийтэд толилуулах, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион явуулах. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2021 онд хэрэгжүүлэх “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийн төлөвлөгөө боловсруулж, хуваарийн хамт Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргаар батлуулан, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 100 жилийн ойн баярын дараа 8,9,10 дугаар сарын үеэр орон нутагт аялан тоглолт хийхээр төлөвлөсөн. Хугацаа болоогүй.

Төлөвлөгөөний 3.7. дахь Цагдаагийн сэдэв (Цагдаагийн байгууллагын түүх, үйл ажиллагаа, онцлох үйл явдлууд, түүхэн хүмүүс, тэргүүний алба, нэгж, алба хаагчдыг сурталчлах, алдаршуулах, мөнхжүүлэх, бахархан дурсах, өөр бусад)-тэй дууны түүврээр кино концерт хийх ажлын хүрээнд Кино концертод орох

цагдаагийн сэдэвт 1 бүжиг, 1 хөгжмийн бүтээл, 7 дууны уран бүтээлийг бүрэн бичиж дууссан. 6 дугаар сарын 26-нд чуулгын уран сайхны зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж, дараах өөрчлөлтүүдийг хийн МҮОНРТ-ийн найруулагч С.Энхтөрд теле концертыг үзүүлж, зөвлөгөө авсны дагуу дуучдын дуулалтын дүрсүүдийг нэмэх шаардлагатай гэж зөвлөсний дагуу засвар хийж, холбоос шүлгүүдийг МҮОНРТ-ийн нэвтрүүлэгч И.Идэрчулуунаар уншуулж, шигтгэсэн байна.

Төлөвлөгөөний 3.8. Цагдаагийн марш хөгжмийн бүтээл туурвих ажлын хүрээнд “Цагдаа”-гийн маршийн хөгжим бүтээх уралдааныг 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр “Сүлд” чуулгын концертын их танхимд цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан үзэгчгүйгээр зохион байгуулсан.

Тус уралдааны Тэргүүн байранд ЦДБЭЧ-ын Ерөнхий хормейстр, МУСТА, О.Эрдэнэцогийн “Цагаан шонхрын тэмүүлэл” марш, Дэд байранд Хилийн цэргийн 0164-р ангийн удирдаач, МУСТА, Д.Отгонтогтоолын “Цагдаагийн тангараг” марш, Гутгаар байранд ахмад уран бүтээлч, МУУГЗ, П.Эрдэнэ-Очирын Түмний хүү “Цагдаа” марш тус тус шалгарсан.

Мөн Эрүүгийн цагдаагийн албанд МУСТА, А.Алтансүхийн “Эрүүгийн цагдаагийн алдар”, Дотоодын цэргийн штабт МУАЖ, П.Хаянхярваагийн “Дотоодын цэргийн жавхлант марш”, Мөрдөн байцаах албанд МУСТА, Н.Даваасүрэнгийн “Мөрдөгчийн гавьяа” маршийг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан.

Уралдаанд шалгарсан 13 маршийг дүрсжүүлэн алба хаагч, ажилтан, иргэд-олон нийтэд хүргэх ажлыг ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төв, Сүлд чуулгын цахим хуудсаар сурталчлав.

Төлөвлөгөөний 3.9. дэх Цагдаагийн байгууллагын түүхэн хөгжлийг харуулсан бүжгийн чуулбар тавих ажлын хүрээнд “Хүндэтгэлийн тоглолт”-д “Бахархал”, “Цагдаагийн чуулбар бүжиг”, “Их хүндэтгэл”, “Эв, Эе”, “Тугт жагсаал”, “Урбан биелгээ”, “Эрхшээгчид” зэрэг бүжгүүдийг толилуулахаар дэглэн найруулж бүрэн дууссан.

Төлөвлөгөөний 3.10. дахь Цагдаагийн бахархалт 100 үзмэрийг багтаасан виртуал музей байгуулах ажлын хүрээнд Виртуал музейн байгуулах гүйцэтгэгч компаний ажилчдын хамт “VR төхөөрөмжөөр үзүүлэх контент бүтээх” ажлын хүрээнд 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Цэцэрлэгт хүрээлэнд байрших Цагдаа цогцолборын орчны зураг авалт, 06 дугаар сарын 27-ны өдөр ЦЕГ-ын Авто баазад хуучны 3, одоо үеийн 9 машины VR зургийг авсан.

100 ширхэг үзмэрийн жагсаалтыг “GDS” ХХК-д гаргаж өгснөөр 2021 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд төлөвлөсөн зураг авалт музейд тусгай павилон засаж зураг авалтыг хийж эхэлсэн.

Музейн 2 давхрын үзмэрийг дэглэх ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагад холбогдох дүрэм журмыг скайнердаж шилэн самбарт оруулах, ЦЕГ-ын СААА-нд хүсэлт тавьснаар 10 ширхэг галт зэвсгүүдийг журмын дагуу хүлээн авч хаяг тайлбарыг бичиж тавих, ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа О.Энхтулгаас өөрийн албандаа хэрэглэж байсан хувийнх нь эд зүйл болох Гэрэл зургийн өсгөгчинд тайлбар, суурь тавиур хийлгэж байршуулах, 4 үеийг төлөөлөх мөрдөсүүдийг шилэн тавиурт тогтоох, НЦУГ-аас 1931 онд үйлдвэрлэсэн тамга /түүхийн хамт/, НЦУГ-ын Хүндэт тэмдэгийг хүлээн авах, Цагдаагийн Ерөнхий газрын

18 шагналаас тус музейд 9 шагналын тэмдэг байсан ба ЦЕГ-ын СААА-наас 5 ш, ЦЕГ-ын ЗУГ-аас 1 ш /ЦЕГ-ын зөвшөөрлөөр олгодог ЭЦА-ы шагнал/, ТЦА-аас 2, НЦУГ-аас 1 ш шагналын тэмдгүүдийн авчирч ХЗДХЯ-ны хүндэт жуух, ЦЕГ-ын хүндэт жуух бичгийг нэмж шагналыг бүрдүүлж шилэн самбарт байршуулах, ТЦА-ы иж бүрэн хувцсыг дагалдах хэрэгслийн хамт ЦЕГ-ын СААА-ны Хангалтын төвөөс хүлээн авах, үе үеийн цагдаа, дотоодын цэргийн хувцаснууд дээр Дотоодын цэргийн генералийн хувцас, 2013 оны дүрэмт хувцасны эмэгтэй хувцсыг өмсүүлж бүрдүүлэх, “Мэдээлэл шуурхай удирдлагын төв 102” буланг холбогдох газартай ярилцаж тохижуулах, ЦЕГ-ын ЦДЦСНТ-өөс эрэлч нохойн албанд холбогдох зүйлсийг бүгдийг татаж авах зэргийг ажлыг хэрэгжүүлсэн.

Төлөвлөгөөний 3.11. дэх Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тууж, роман, зохиолын уралдаан зохион байгуулж, шалгаруулах ажлын хүрээнд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тууж, роман, зохиолын уралдаан зохион байгуулж, шалгаруулах” ажлыг зохион байгуулж, Тууж төрөлд 9 бүтээл ирүүлснээс Монголын зохиолчдын эвлэлийн шагналт зохиолч С.Батжаргалын “Өр төлөөс” тууж тэргүүн байр, Монголын зохиолчдын эвлэлийн шагналт зохиолч С.Пүрэвсүрэнгийн “Монгол Улсын төлөө зүтгэе” тууж дэд байр, Монголын зохиолчдын эвлэлийн шагналт зохиолч, яруу найрагч Г.Ганболдын “Хүрээ аллага” тууж гутгаар байранд тус тус шалгарсан.

Роман төрөлд 2 бүтээл ирүүлснээс залуу зохиолч Х.Буянбатын “Бидний амар тайван амьдрал” экспериментал роман гутгаар байранд шалгарсан.

Тус уралдаанд шалгарсан уран бүтээлчдэд олгох шагнал, бусад зардалд шаардлагатай 12.780.000 төгрөгийг төсвийг шийдвэрлүүлж, шагнал гардуулах ёслолыг Сүлд чуулгын концертын их танхимд 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа.

Уралдаанд шалгарсан уран бүтээлийг сонсох /audio/ хэлбэрээр бэлтгэх, иргэд олон нийтэд сурталчлах, зохиолчдыг алдаршуулах ажлыг ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төв, Сүлд чуулгатай хамтран зохион байгуулахаар төлөвлөж байна.

Төлөвлөгөөний 3.12. дахь Цагдаагийн байгууллагын сүр хүч, бэлгэ тэмдэг болох “Цагаан шонхор” 3D видео анимешнь хийлгэх ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагын сүр хүч, бэлгэ тэмдэг болох “Цагаан шонхор” 3D видео анимешний аяыг хөгжмийн зохиолч, МУСТА Д.Мягмардоржоор бичүүлэн, “Рекфокус” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, “Цагаан шонхор” 3D видео анимешнийг бүтээлгэн, ЦЕГ-ын удирдлагуудад танилцуулсан.

Төлөвлөгөөний 3.13. дахь Ардын хувьсгалын 100, Цагдаагийн байгууллагын 100 жилийн ойд зориулж “Эрхэм төрийн тамгат баатрууд” түүхэн дуулалт дууль дэглэн тавих. “Эрхэм төрийн тамгат баатрууд” дуулийн дүр хуваарилалтыг хийж, 14 гол дүрийн дуучид дүрээ сонгон авч, бэлтгэлийг хангуулж байна. Хоороор олны хэсэгт дуулагдах Баян сүм, Баян Монгол, Жанжин туг, Дөрвөн уул, Соёл эрдэнэ, Гялайв уу, Дамбийжаа /эмэгтэй цөөхүүл/ зэрэг 7 дуун дээр хөгжим, бүжиг, дуу ангиуд УДБЭТ-ийн хормейстер Н.Дашбямба багштай 4 болон 8 хоолой мөн, эмэгтэй цөөхүүл дууны найруулгууд хийгдсэн байна.

Төлөвлөгөөний 3.14. дэх Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд ашиглагдах хөгжмийн зэмсэг, техник, тоног төхөөрөмж, хувцас, хэрэглэлийг бэлтгэх, хангах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд “Хүндэтгэлийн тоглолт”-ын 3 бүжгийн 60 хувцас хэрэглэлийг “Азын мод”

ХХК-иар оёулж бэлэн болсон. 11 хөгжим Япон улсаас захиалж, нислэг хүлээгдэж байна. Цахилгаан хөгжмийн зэмсэг БНСУ-аас Монголруу хийгдэх нислэгийг хүлээж байна. Эрэгтэй хөгжимчдийн 20 ширхэг хувцсыг Тэлмэн жороо ХХК-иас хүлээж авсан. Эмэгтэй хөгжимчдийн 4 даашинзыг хүлээн авахад бэлэн болсон. Ёслолын Цагаан өнгийн китель оёгдох явц 90%-тай байна.

Төлөвлөгөөний 3.15. Цагдаагийн албаны түүхэн дууны ном хэвлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт Сүлд чуулгын 2020 оны 26/417 дугаар албан бичгээр хамтран ажиллах хүсэлт хүргүүлж, 36 алба, газар, хэлтсээс 58 дуу ирүүлсэн байна. Одоогийн байдлаар 250 дууны нот, шүлгийг бэлтгэсэн бөгөөд номыг хэвлүүлэхэд шаардагдах 12.880.000 төгрөгийн төсвийн задаргаа, хэвлэх 3 үйлдвэрийн үнийн судалгааг боловсруулж, ажлын хэсгийн хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэн хэвлэлтэд өгсөн байна.

Уран бүтээлийн чиглэлээр

Эхний хагас жилд Бүжиг анги 100 жилийн ойн хүндэтгэлийн тоглолтод орох 5 бүжгийн 3 бүжгийг дэглэн найруулж, бэлэн болгон бэлтгэл сургуулилтыг хийж байна. 100 жилийн ойн хүрээнд тавигдах “Эрхэм төрийн тамгат баатрууд” түүхэн дуулалт дуулийн 2 бүжгийг дэглэн тавьсан.

Бүжгийн багш, бүжиг дэглээч, цагдаагийн дэслэгч Ё.Дамчаабадгар Дэлхийн бүжгийн хорооноос зохион байгуулсан олон улсын мэргэжлийн бүжигчдийн онлайн уралдаанаас “Шилдэг бүжигчин”, “Шилдэг багш”, “Шилдэг үзүүлбэр”-ийн 3 шагналыг хүртлээ.

Үлээвэр хөгжимчид шинээр 3 уран бүтээл хийж, 8 удаагийн арга хэмжээнд үйлчилж, удирдах ажилтны сургалт, зөвлөгөөний нээлтийн үеэр эгшиглүүлэх “Төрийн дуулал”-ыг Хүн театрт бичүүлж, олон нийтэд хүргэж, цагдаагийн маршийн уралдаанд шалгарсан 4 маршийн бичлэгийг хийлгэв.

Дуучид сар шинийн баярыг угтан “Жаргалтайн дэлгэр” теле нэвтрүүлгийг бэлтгэн 4 телевизийн эфирээр цацав. Сүлд телевизээр “Монгол цэргийн едер”-т зориулан бэлтгэсэн нэвтрүүлэгт оролцож 1 уран бүтээлийг дүрсжүүлэн цахимаар сурталчлав.

Хууль зүй, дотоодын хэргийн яам үүсэн байгуулагдсаны 110, Цагдаагийн байгууллагын 100 жилийн ой угтсан ажлын хүрээнд ахмад үеийнхээ гавьяат үйлсийг менхжүүлэх, тэдний баатарлаг дайчин уламжпалаас суралцах, үлгэр дууриал авах зорилгоор чуулгын даргын 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/01 дугаар тушаалаар дуу ангийг үүсгэн байгуулах ажлыг удирдаж, анхны хор-мэйстер багшаар ажиллаж байсан МУСТА Сэдийн Галсанцэдэн агсаны нэрэмжит, бүжгийн тэнхмийг "Сүлд" чуулгын анхны бүжгийн багш, Монгол Улсын Гавьяат жүжигчин Данзангийн Ламжавын нэрэмжит, хөгжим ангийг Цагдаагийн үлээвэр найрал хөгжмийг 1991 онд үүсгэн байгуулж анхны удирдаачаар нь ажиллаж байсан Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан, сурган хүмүүжүүлэгч, цагдаагийн хошууч Гомбын Нямжавын нэрэмжит өрөө болгосон.

Чингис хаан одонт, Монгол Улсын гавьяат жүжигчин Г.Ариунбаатар ОХУ-ын Батлан хамгаалах яамны “Гавьяаны төлөө” медалиар, гэрлийн найруулагч Нямцэрэнгийн Ганбат нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны 14 дүгээр зарлигаар “Аптан гадас” одонгоор шагнагдлаа.

Бусад ажил

Чуулгын байранд Цагдаа, дотоодын цэргийн түр хүрээгээр 5 удаа, өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан өдөр бүр ариутгал, халдваргүйжүүлэлт хийж дүнг Нийслэлийн цагдаагийн удирдах газарт өдөр бүр мэдээ өгч ажилласан. Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлд оруулахгүй байх үүднээс давхардсан тоогоор 210 алба хаагчийг PCR шинжилгээнд хамруулсан. Чуулгын 64 алба хаагчийг Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулатори болон Төрийн тусгай алба хаагчдын нэгдсэн эмнэлэгт Коронавирусээс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан. Коронавирусын /Ковид-19/-ын халдвар авч гэрээр болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 9 алба хаагч, ажилтантай холбогдон эрүүл мэнд, сэтгэл санааны байдлыг тандаж гэр бүлд шаардлагатай хүнс эм тариа, дархлаа дэмжих амин дэм авах зэрэгт нь зориулж дундын сангаас мөнгөн тусламж үзүүлж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн “Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” хаалттай группд тус чуулгын алба хаагчдыг нэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж 50 алба хаагчийг нэгтгэсэн нь алба хаагчдыг өөрийн хууль ёсны эрх ашиг сонирхол хамгаалуулах, өөрт тулгамдаж буй асуудлыг хэлж шийдвэрлүүлэх боломжтой болсон ач холбогдолтой.

Чуулгын хэмжээнд “Ойдоо барих бидний бүтээлч ажил” сэдэвт тохижилтын уралдааныг алба хаагч, ажилчдын дунд зохион байгуулж Бүжиг анги эмэгтэйчүүдийн өрөөнд дроз, бүжгийн заалны хөшиг эрэгтэй бүжигчдийн өрөөний засвар, Хөгжим анги бөмбөрийн подставка, хаалт, урлагийн их танхимийн яамны подставка, Дуу анги өрөөний дуулаачийн багш, дууны хэсгийн ахлагчийн өрөө, эмэгтэй дуучдын өрөө, дууны хэсгийн үүдний коридорын засварын ажил, Захиргаа алба хаагч, ажилтан нарын аюулгүй байдлыг хангах, түргэн цугларах, мэдээ мэдээллийг цаг тухайд хүргэх зарлан мэдээлэл систем, цагдаагийн музейн эрхлэгч, найруулагч, аж ахуйн ажилтан, музейн сан хөмрөгч, бүртгэл, мэдээллийн ажилтан нарын өрөөний засварын ажил хийсэн. Уралдаанд Хөгжим ангийн хамт олон тэргүүлж, Бүжиг анги дэд байр, Захиргааны удирдлагын тасаг гутгаар байрт шалгарч, чуулгын удирдлагаас шагнаж урамшуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр” болон танилцуулга, 1 цагийн сургалтыг Сүлд цахим тайз нэртэй хаалттай цахим группт байршуулж чуулгын 70 алба хаагчдад мэдээлэл өгсөн. Алба хаагчдын эрх, хууль ёсны эрх ашиг хөндөгдсөн, зөрчигдсэн, гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон тохиолдолд нэн даруй харьяалах дарга, удирдлагадаа мэдэгдэж байх талаар алба хаагчдад чиглэл өгсөн.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанаас цагдаагийн байгууллагын нийт алба хаагчдыг гэнэтийн ослын даатгалд 2020 оны 07 дугаар сард хамруулснаас Сүлд чуулгын бүх алба хаагч, ажилтныг Практикал даатгалд бүрэн хамруулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанаас 2021 оны хөрөнгө оруулалтаар тус чуулгын 3 дугаар давхар “Цагдаагийн музей”, шатны хонгил, 1 дүгээр давхарын ариун цэврийн өрөө, гадна талбай, байрны гадна нүүрний фасад зэрэг 283.0 сая төгрөгийн засварын ажлын тендерийг хууль тогтоомжид нийцүүлэн зарлахад тус чуулгын барилгын засварын ажлын тендерт “Энх энэрэлийн өргөө”

ХХК шалгарч 147.0 сая төгрөгийн гүйцэтгэл хийгдэж засварын ажил 50%-тай явагдаж байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН “СҮЛД” ЧУУЛГА